

Монголын “Шинжлэх ухааны ажилтны одор”, БХЭШХ-ийн 35 жилийн ойн арга хэмжээний хүрээнд БХЭШХ-ээс 10 гаруй эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулиудын дунд гар бомбог, ширээний теннис, шатрын тэмцээнийг амжилттай зохион байгуулж явууллаа. Шатрын тэмцээнд 10 багийн 30 тамирчин оролцсоноос спортын мастер, хурандаа Ж.Болдбаатар ахлагчтай Хууль Сахиулахын Их сургуулийн баг алтан медаль, Үндэсний тагнуулын академийн баг монгон медаль, доктор, профессор А.Хvv-Ухнаа ахлагчтай Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн баг хүрэл медалийг тус тус хүртлээ. Тус тэмцээнд Монголын шатрын холбооны дэд тэргvн, Стратегийн судалгааны хүрээлэнгийн дэд захирал, спортын мастер Ч.Чулуунбаатар зэрэг спортын мастер 4, нэгдүгээр зэрэгтэй 7 тамирчин оролцсон нь тэмцээний чансааг харуулж байлаа. Тэмцээний еронхий шvvгчээр Цэргийн боловсрол, сургалт судалгааны товийн дарга, доктор, профессор Т.Соронзонболд, нарийн бичгийн даргаар доктор, профессор П.Цэдэв нар ажиллав